

МОНГОЛБАНК-нд

Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнийн ажлын тайлан

2023 оны 02 дугаар улирал

2023 оны 07 дугаар
сарын 05-ны өдөрУлаанбаатар
хот

Ажлын тайлан

Миний бие П.Мөнх-Эрдэнэ нь “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын болон Хүний нөөц, цалин урамшууллын хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хурлууд, Аудитын хорооны хуралд оролцож холбогдох хурлыг удирдаж, тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан. Хүснэгтээр харуулбал:

Хуралд оролцсон байдлаар №1:

| № | Хувьцаа эзэмшигчдийн хурал | ТУЗ-ийн хурал | Аудитын хорооны хурал | Эрсдэлийн хорооны хурал | Нийт оролцсон хурал |
|----|----------------------------------|------------------|--------------------------|----------------------------|------------------------|
| 1. | 2 | 8 | 2 | 0 | 12 |

Хурал хуралдсан огноогоор №2:

| № | Хувьцаа эзэмшигчдийн хурал | ТУЗ-ийн хурал | Аудитын хорооны хурал | Эрсдэлийн хорооны хурал |
|----|-------------------------------|--|--------------------------|----------------------------|
| 1. | 2023-04-28 2023-05-04 | 2023-04-12 2023-04-18 2023-04-19 2023-05-11 2023-05-24 2023-05-29 2023-06-16 2023-06-28 | | 2023-04-25 2023-06-08 |

Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:

| № | Сонирхлын зөрчилтэй асуудал | Их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал |
|----|--------------------------------|---|
| 1. | 1 | |

Тайлант хугацаанд танхимаар удаа хуралдсан бөгөөд банкны Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ, Аудитын хорооны хурлыг нийт 12 удаа даргалан оролцож, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

ТУЗ-ийн дарга, гишүүний хувьд:

1. Тогтворжуулах төлөвлөгөө батлах,
2. Банкны 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт батлах,
3. ХЭ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
4. Ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэх,
5. Банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэх,
6. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн батлах,
7. Банкны тогтворжуулах төлөвлөгөө Монголбанкны нэмэлт шаардлагын дагуу сайжруулан шинэчлэх,
8. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлттэй танилцаж шийдвэрлүүлэхээр ирүүлсэн асуудлыг батлах;
9. ТУЗ-ийн бүрэлдэхүүн 9 гишүүнтэй болсонтой холбоотойгоор НБД-г томилох, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах, гишүүдийг томилох,
10. Гүйцэтгэх захирлын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах зэргээр ажиллаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 1 удаагийн хэлцэлд зөвшөөрөл өгөхөд саналаа өгсөн.

1. Гүйцэтгэх захирлын ажлын хэрэгцээнд автомашин худалдан авах эрх олгох,

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргын хувьд:

1. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газрын аудитораар 2 ажилтныг сонгон туршилтын хугацаанд ажиллуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

ТУЗ-н хараат бус гишүүний хувьд дараах зарчим, зорилтуудад Банк анхаарлаа хандуулж байгааг онцлон хэлмээр байна.

- ТУЗ-н үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай, хуулийн хугацаанд зохион байгуулсан.
- Монголбанкнаас ирүүлсэн мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг,
- ТУЗ-с засаж залруулах боломжтой асуудлууд байгаа тохиолдолд бид ТУЗ-н түвшинд хэлэлцүүлгийг эхлүүлж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар удирдамж өгч, эргэн тайлагнах хугацааг өгдөг. Удирдлагын баг эдгээр хүсэлтийг дагаж мөрдөж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авдаг.
- Тайлангийн хугацаанд Банкны хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй.
- ТУЗ нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- ТУЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй бөгөөд хэрэв надад асуулт байгаа эсвэл нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТУЗ болон Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.

- Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-с гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс сайтар судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайлангаа тайлагнав.

ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх хороодын зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд Банкны тухай хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулж 3 хараат бус, 6 ердийн гишүүнийг бүрдүүлэн холбогдох зөвшөөрлийг Монголбанкнаас авч бүтэц бүрэлдэхүүн, засаглалын зохистой зарчмыг хэрэгжүүлэн ажиллаа.

Мөн Ариг банк 2022 оны TOP 100 аж ахуйн нэгжээр шалгарсан ажилттай ажилласан байна.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг барьж ажиллахыг чармайж ирсэн болно.

Тайлан бичсэн:

Ариг банкны ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн,

Аудитын хорооны дарга,

Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн

Хүний нөөц, цалин урамшууллын хорооны гишүүн

П.Мөнх-Эрдэнэ

